

“УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН БАРИЛГЫН ИНЖЕНЕРИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

ЕРӨНХИЙ ЗОРИЛГО

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих замаар өсөн нэмэгдэж буй дэд бүтцийн хэрэгцээг хангаж, байгаль орчныг бохирдлоос хамгаалж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

1. Барилга байгууламжийн зураг төсөв, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хянаж, шаардлагатай тохиолдолд төсөв хийх, залруулга хийлгэх, зөвшилцөх;
2. Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, ажил эхлүүлэх зөвшөөрөл авах ажлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
3. Барилгын ажлын явц, үе шатны ажлын гүйцэтгэлийн чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын актыг хянаж баталгаажуулах;
4. Барилгын ажлын үе шатны гүйцэтгэл, санхүүжилтийн дүнг хянах;
5. Барилга байгууламж барих талбайг чөлөөлөх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх асуудлыг хариуцах;
6. Барилга байгууламж барих, шинэчлэх, засварлахтай холбогдон гудамж, зам, талбай сэтлэх, шугам сүлжээ болон холболт хийхэд мод, ногоон байгууламжийг түр зайлуулах, түүний нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхэд хяналт тавих;
7. Гүйцэтгэгчээр барилгын ажлын явцад зураг төслийн анхны шийдлээс өөрчлөгдсөн тохиолдолд зураг төсөл зохиогчтой зөвшилцөж, гүйцэтгэсэн үе шатны ажил бүрд гүйцэтгэлийн зургийг хийлгэж, зургийн зохиогчийн зөвшөөрлөөр баталгаажуулах;
8. Шаардлагатай үед барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийхэд хамтран ажиллаж зөрчил дутагдлыг залруулахад хяналт тавих;
9. Гүйцэтгэгч барилгын норм, дүрэм, стандарт, зураг төслийн техникийн тодорхойлолтын шаардлага бүрэн хангасан материал, эдлэхүүнийг

нийлүүлж, угсралт хийж байгаад хяналт тавьж, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах, холбогдох баримт бичгийг хянах;

10. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх болон ашиглалтад оруулахтай холбогдсон асуудлыг хариуцан зохион байгуулж гүйцэтгэх;
11. Барилгын ажлын өдөр тутмын хяналтыг гүйцэтгэх үүрэг бүхий орон нутагт ажиллах инженерүүдийг мэргэжлийн удирдамж чиглэлээр ханган хамтарч ажиллах;
12. Барилгын ажлыг гүйцэтгэх ажлын хуваарийн биелэлтийг хянаж, явцын тайлан мэдээг гаргаж танилцуулж байх;
13. Шаардлагатай бусад ажлыг хийж гүйцэтгэх.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол:

- ✓ Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй.

Мэргэжил:

- ✓ Барилгын инженер,
- ✓ Барилгын сантехникийн инженер,
- ✓ Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер

Туршлага:

- ✓ Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- ✓ Мэргэжлээрээ төсөл хөтөлбөрт ажиллаж байсан бол давуу тал болно;

Ур чадвар:

- ✓ Мэргэшсэн инженер байх /мэргэжлийн дагуу/;
- ✓ Баримт бичиг боловсруулах ур чадвартай байх;
- ✓ Компьютерын албан хэрэгцээний MS Office, мэргэжлийн AutoCAD программ болон бусад шаардлагатай программыг эзэмшсэн байх;
- ✓ Удирдан зохион байгуулах, багаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

ОРОЛЦОГЧДОД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ

Мэдүүлэг гаргагч нь шаардлага хангаж буйг нотлох дараах баримтыг дарааллын дагуу бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкет. /бүрэн бөглөсөн байх/;
2. Товч намтар;
3. Иргэний үнэмлэхийн лавлагаа;
4. Боловсролын диплом, гэрчилгээ;
5. Мэргэшлийн үнэмлэх;

6. Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа, ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал (байж болно)/-ын хуулбар;
7. Өмнөх буюу одоогийн ажлын газрын тодорхойлолт /байж болно/, мэргэжлийн ур чадвар, туршлагыг нотлох мэдээлэл, баримт.

Санамж: Хэрэв дээрх барим бичгийн аль нэг нь байхгүй тохиолдолд сонгон шалгаруулалтын материалын бүрдэл дутуу гэж үзэн тэнцээгүйд тооцно.

Дээрх шаардлагыг хангасан сонирхогч этгээд шаардлагатай баримт бичгийг дараах хаягт дугтуйлж 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 10:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Барилгачдын талбай 3, Засгийн газрын 12 байр 318 тоот

Тодруулга авах утас: 51-261718

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Монгол улсын засгийн газар Хот байгуулалт, Барилга, Орон сууцжуулалтын яам
3. Төсөл, арга хэмжээний нэр, дугаар: “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”	3.1. Орон тоо, албан тушаал: Барилгын инженер
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны удирдлагууд, төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн захирал, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч	

Б. ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээр, Сангийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийг 196 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/12 дугаар тушаал болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн барилга угсралтын ажилд хяналт тавих, зохион байгуулж ажиллана.		
2. Ажлын байрны дэд зорилтууд:	1. “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн барилга угсралтын ажлын гэрээний гүйцэтгэлийг БНБД, MNS стандартын хүрээ, Монгол Улсын холбогдох хууль журам болон гэрээнд заасан бусад олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хяналт тавьж ажиллах; 2. Удирдлагаас хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;		
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа: Журам болон Хөлсөөр ажиллах гэрээнд тухайн ажлын байртай холбоотой тусгасан ажил үүргийг зайлшгүй тусгах	Хугацаа, хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
Ажлын байрны 1 дүгээр зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүрэг:			
1.1. Барилга байгууламжийн зураг төсөв, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хянаж, шаардлагатай тохиолдолд төсөв хийх, залруулга хийлгэх, зөвшилцөх; 1.2. Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл, ажил	2025 оны I-IV улиралд	Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Барилгын норм ба дүрэм, шаардах хуудас, үүрэг даалгаврын биелэлтийн	


<p>эхлүүлэх зөвшөөрөл авах ажлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>1.3. Барилгын ажлын явц, үе шатны ажлын гүйцэтгэлийн чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын актыг хянаж баталгаажуулах;</p> <p>1.4. Барилгын ажлын үе шатны гүйцэтгэл, санхүүжилтийн дүнг хянах;</p> <p>1.5. Барилга байгууламж барих талбайг чөлөөлөх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэх асуудлыг хариуцах;</p> <p>1.6. Барилга байгууламж барих, шинэчлэх, засварлахтай холбогдон гудамж, зам, талбай сэтлэх, шугам сүлжээ болон холболт хийхэд мод, ногоон байгууламжийг түр зайлуулах, түүний нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхэд хяналт тавих;</p> <p>1.7. Гүйцэтгэгчээр барилгын ажлын явцад зураг төслийн анхны шийдлээс өөрчлөгдсөн тохиолдолд зураг төсөл зохиогчтой зөвшилцөж, гүйцэтгэсэн үе шатны ажил бүрт гүйцэтгэлийн зургийг хийлгэж, зургийн зохиогчийн зөвшөөрлөөр баталгаажуулах;</p> <p>1.8. Шаардлагатай үед барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийхэд хамтран ажиллаж зөрчил дутагдлыг залруулахад хяналт тавих;</p> <p>1.9. Гүйцэтгэгч барилгын норм, дүрэм, стандарт, зураг төслийн техникийн тодорхойлолтын шаардлага бүрэн хангасан материал, эдлэхүүнийг нийлүүлж, угсралт хийж байгаад хяналт тавьж, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах, холбогдох баримт бичгийг хянах;</p> <p>1.10. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх болон ашиглалтад оруулахтай холбогдсон асуудлыг хариуцан зохион байгуулж гүйцэтгэх;</p> <p>1.11. Барилгын ажлын өдөр тутмын хяналтыг гүйцэтгэх үүрэг бүхий орон нутагт ажиллах инженерүүдийг мэргэжлийн удирдамж чиглэлээр ханган хамтарч ажиллах;</p> <p>1.12. Барилгын ажлыг гүйцэтгэх ажлын хуваарийн биелэлтийг хянаж, явцын тайлан мэдээг гаргаж танилцуулж байх;</p> <p>1.13. Шаардлагатай бусад ажлыг хийж гүйцэтгэх.</p>		<p>дагуу захиалагчийн хяналтын чиг үүргийг гэрээний хүрээнд ил далд ажлын акт хянаж баталгаажуулах, барилга угсарлтын үе шатны ажлыг хариуцан гүйцэтгэх, хянах, шийдвэрлэх</p>
<p>Ажлын байрны 2 дугаар зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүрэг:</p>		

<p>2.1. Мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах;</p> <p>2.2. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй боловч цаг үеийн ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;</p> <p>2.3. Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.</p>	<p>2025 оны I-IV улиралд</p>	<p>Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь бүрэн хариуцан гүйцэтгэх, хянах, шийдвэрлэх</p>
<p>Тайлбар: Ажилтны ажил үүргээ гүйцэтгэх хугацаа, хуваарийг төсөл, арга хэмжээний тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.</p>		

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

		Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
<p>1. Ажлын байранд тавигдах шаардлага</p>	<p>1.1. Ерөнхий шаардлага:</p>	Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
		Мэргэжил	Барилгын инженер, Барилгын сантехникийн инженер, Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	Барилгын инженер, Барилгын сантехникийн инженер, Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер
		Туршлага	-Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх; -Онцгой төвөгшилтэй болон цэвэрлэх байгууламж, барилга байгууламжийн захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.	-Салбартаа 5-аас доошгүй жил ажилласан байх; -Мэргэжлээрээ төсөл хөтөлбөрт ажиллаж байсан бол давуу тал;
		Ур чадвар	-Баримт бичиг боловсруулах ур чадвартай байх;	-

			-Компьютерын албан хэрэгцээний MS Office, мэргэжлийн AutoCAD программ болон бусад шаардлагатай программыг эзэмшсэн байх; -Удирдан зохион байгуулах, багаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.	
	1.2. Тусгай шаардлага:		Мэргэшсэн инженер байх /Мэргэжлийн дагуу/	

<p>АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛГААЖУУЛСАН:</p> <p>ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ТӨМӨРХҮҮ</p> 	<p>АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ ХЯНАСАН:</p> <p>ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.БАТЗАЯА</p> <p>АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БОЛОВСРУУЛСАН:</p> <p>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧИЙН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЧИНЗОРИГ</p>
---	--